



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/562

Улаанбаатар хот

Монгол Улсын Их сургуулийн
Зэргийн бус сургалтын журам
батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 19 дүгээр зүйлийн 19.6, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.9 дэх хэсэг, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монгол Улсын Их сургуулийн Зэргийн бус сургалтын журам”-ыг хавсралтаар баталж, 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү журмыг холбогдох нэгжүүдэд сурталчлан, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлууд (Б.Болд-Эрдэнэ, Ц.Амартайван, Н.Батнасан, Б.Амарсанаа, Ч.Сономдавга, Б.Ганбат, Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-д үүрэг болгосугай.

РЕКТОР




Б.ОЧИРХУЯГ

1425064900

Монгол улсын их сургуулийн ректорын
2025 оны 11 дүгээр/дугаар сарын 22 -ний/ны
өдрийн А/562 тоот тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗЭРГИЙН БУС СУРГАЛТЫН ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журам, МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журмын хүрээнд насан туршийн боловсрол олгох зорилгоор МУИС-ийн зэргийн бус сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, түүний чанарын баталгаажуулалтыг хангахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Энэхүү журам нь МУИС-ийн зэргийн бус сургалтын удирдлагын мэдээллийн системд бүртгэлтэй, баталгаат гэрчилгээтэй, багц цаг бүхий сургалтыг хамаарна. Зэргийн бус сургалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, суралцахуйн үр дүнд чиглэсэн, хөтөлбөрт тавих шаардлагын дагуу боловсруулсан хөтөлбөртэй, чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.
- 1.3. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны аль нэг чиглэлээр эсвэл салбар дундын агуулгаар ажлын байранд шаардлагатай тодорхой мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэх, чадавхжуулах хүрээнд боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4. МУИС-ийн зэргийн бус сургалт нь сургалтын удирдлагын мэдээллийн системтэй байх бөгөөд хуулиар хориглоогүй мэдээлэл нь нийтэд нээлттэй байна. Захиалгат сургалтын хувьд хөтөлбөр болон холбогдох багш нарын мэдээллийг ил болгохыг шаардахгүй.

Хоёр. Журмын нэр томьёо

- 2.1. Насан туршийн боловсрол (Lifelong Learning) гэж иргэн өөрийн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус, зэргийн бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг;
- 2.2. Зэргийн бус сургалт (Micro-Credentials) гэж хувь хүн, албан байгууллага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн, шинжлэх ухааны аль нэг салбар, мэргэжлийн чиглэлээр тодорхой мэдлэг, ур чадвар, хандлага олгоход чиглэсэн, үнэлгээний аргачлал, багц цагийн системтэй, хичээлийн индекс, чанарын баталгаа бүхий сургалтыг;
- 2.3. Зэргийн бус сургалтын хөтөлбөр (Micro-Credentials Program) гэж тодорхой мэргэжлийн ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлийн хүрээнд системтэй мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэх зорилго бүхий боловсролын зэрэг олгохгүй хөтөлбөрийг;

- 2.4. Зэргийн бус сургалтын суралцагч гэж зэргийн бус сургалтад хамрагдаж буй иргэн, их, дээд сургуульд суралцаж буй оюутан, суралцагч, өмнө нь боловсролын зэрэг эзэмшсэн иргэн, хөдөлмөр эрхэлж буй иргэн, зарим тохиолдолд ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчийг;
- 2.5. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн баримт бичиг гэж мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшүүлэх сургалтын төлөвлөгөө болон хичээл тус бүрийн зорилго, агуулга, суралцахуйн үр дүн багц цаг, үнэлэх аргачлал бүхий хөтөлбөр, чанарын баталгаажуулалт зэргийг багтаасан цогц баримт бичгийг;
- 2.6. Захиалгат зэргийн бус сургалт гэж захиалагчийн хүсэл, хэрэгцээнд тулгуурлан, гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу олгох насан туршийн боловсролыг;
- 2.7. Сургалт зохион байгуулагч гэж оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн, Ректорын тушаалаар байгуулсан ажлын хэсгийг;
- 2.8. Хамтран зохион байгуулагч гэж зэргийн бус сургалтыг МУИС-тай хамтран зохион байгуулахаар гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;
- 2.9. Гэрчилгээ гэж зэргийн бус сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн суралцагчид олгох, сургалтын агуулга, цаг эсвэл багц цаг, дүн үнэлгээ, давтагдашгүй баталгаат дугаар бүхий албан ёсны (хэвлэмэл, цахим) баримт бичгийг;
- 2.10. Хичээлийн цаг гэж байгалийн цагийн 50 минутыг; дараалсан 2 цагийн хичээлийг дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулж болно;
- 2.11. Хичээлийн багц цаг гэж тухайн хичээлийн агуулгын багтаамж, ачааллыг илэрхийлсэн, суралцахуйн үр дүнг эзэмшүүлэхийн тулд төлөвлөсөн хичээлийн нийт цагийг илэрхийлсэн нэгжийг хэлнэ.

Гурав. Зэргийн бус сургалтын агуулга, төрөл, хэлбэр

- 3.1. Зэргийн бус сургалтын чиглэл, агуулга нь мэргэжлийн чиглэлийн онцлог, нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, захиалагчийн шаардлагаас хамааран шинжлэх ухаан, техник технологийн тодорхой салбараар төрөлжсөн эсвэл салбар дундын цогц чадамжийг олгоход чиглэсэн байна.
- 3.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрт мэргэжлийн чиглэлийн дагуу суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна.
- 3.3. Зэргийн бус сургалтын хөтөлбөрт сургалтын төлөвлөгөө болон хичээл тус бүрийн зорилго, агуулга, суралцахуйн үр дүн, арга зүй, үнэлэх аргачлал бүхий хөтөлбөр, элсэгч, багш, төгсөгчид тавих шаардлага, орчин, хэрэглэгдэхүүн, чанарын баталгаажуулалт зэргийг тусгана.
- 3.4. Зэргийн бус сургалт нь бие даасан зэргийн бус хичээл болон бакалавр, магистр, докторын түвшний зэргийн хөтөлбөрийн хичээлээс бүрдэж болно. Зэргийн бус сургалтын суралцагчийн судалсан хичээлийн багц цагийг мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн зэргийн хөтөлбөрийн хичээлд дүйцүүлэн тооцож болно.
- 3.5. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн агуулга, зохион байгуулалтад дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.5.1. үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх;
- 3.5.2. улс төр, шашин, эрх чөлөө, энх тайвны эсрэг үзэл суртал, нас, хүйс, арьс өнгө, нийгмийн гарал үүслээр ялгаварлан гадуурхахгүй байх;
- 3.5.3. иргэн бүрд нас, хүйс, боловсролын түвшин үл харгалзан суралцах тэгш боломжийг олгохуйц тэгш хамран сургах боловсролын зарчмыг баримтлах;

- 3.5.4. хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийг олгоход чиглэсэн байх;
- 3.5.5. чанарын үнэлгээ тогтмол хийдэг байх;
- 3.5.6. суралцагч төвтэй, үр дүнд суурилсан байх;
- 3.5.7. тогтвортой, уялдаатай, уян хатан, нээлттэй байх;
- 3.5.8. боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, эдийн засгийн үр ашигтай байх зарчим.
- 3.6. Зэргийн бус сургалтыг МУИС-ийн нэгжүүд дангаар болон хамтарч эсвэл гадаад, дотоодын түнш байгууллагуудтай хамтран зохион байгуулж болно.
- 3.7. Зэргийн бус сургалт дараах гурван төрөлтэй байна. Үүнд:
- 3.7.1. Зэргийн бус сургалтад зориулан боловсруулсан хичээл бүхий сургалт;
- 3.7.2. Зэргийн хөтөлбөрийн хичээлээс бүрдсэн сургалт;
- 3.7.3. Дээрх хоёрыг хосолсон сургалт.
- 3.8. Зэргийн бус сургалт анхан, дунд, ахисан түвшинтэй байж болох ба энэ тохиолдолд өмнөх түвшний сургалтад хамрагдсан эсвэл түвшин тогтоох шалгалтыг амжилттай өгсөн суралцагч дараагийн түвшинд элсэн суралцах боломжтой.
- 3.9. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн нийт багц цаг 2-30 байна.
- 3.10. Батлагдсан хөтөлбөрийг танхим, цахим болон хосолсон хэлбэрээр, мөн монгол эсвэл гадаад хэлээр хэрэгжүүлж болно.
- 3.11. Сургалтын үргэлжлэх хугацаа богино (1 сар хүртэл), дунд (2-3 сар), урт (хичээлийн жилийн 1-2 улирал) хугацааны байж болно.
- 3.12. Бүрэлдэхүүн/салбар сургууль хэрэгжүүлж буй зэргийн хөтөлбөрт хамаарахгүй чиглэлээр сургалт явуулахгүй бөгөөд дээрх тохиолдолд холбогдох талуудтай хамтран зохион байгуулна.

Дөрөв. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн удирдлага

- 4.1. МУИС-ийн зэргийн бус сургалтын үйл ажиллагааг сургалт эрхэлсэн проРектор нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж, Бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхим, бусад нэгжүүд холбогдох хууль тогтоомж, МУИС-ийн дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хамтран ажиллана.
- 4.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг баримталсан байна. Үүнд:
- 4.2.1. Хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлт хэрэгцээ, насан туршийн боловсролын олон улсын жишигт нийцсэн, шинжлэх ухааны мэдлэг, ур чадварт суурилсан байх;
- 4.2.2. Салбарын хууль эрх зүй, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, мэргэшлийн тодорхойлолт, стандарт шаардлага, олон улсын хандлагыг харгалзан үзсэн байх;
- 4.2.3. Хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх, хөгжүүлэхэд багш, салбарын шинжээч, ажил олгогчдын төлөөллийг оролцуулж, суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тогтмол тусгах боломжийг хангасан байх;
- 4.2.4. Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдаа холбоотой боловсруулж, нийтэд нээлттэй тавьсан байх;
- 4.2.5. Хөтөлбөрийн санхүүгийн үр ашгийн тооцоо хийсэн байх;
- 4.2.6. Суралцахуйн үр дүнг хүрэх боломжтой, үнэлэгдэхүйц, сургалтын түвшин, агуулга, хэмжээ, хугацаатай уялдсан байдлаар тодорхойлсон байх;
- 4.2.7. Сургалтын төгсгөлд суралцахуйн үр дүнгээр тодорхойлсон мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байхаар төлөвлөх;

- 4.2.8. Төгсөгч нь салбарын мэргэшлийн шаардлага стандарт, хууль тогтоомжид нийцсэн суралцахуйн үр дүнд хүрсэн байх;
- 4.2.9. Суралцагчдын хүлээлт, эрэлт хэрэгцээ, суралцагчийн түвшин, онцлогийг харгалзан сургалтаа явуулдаг байх;
- 4.2.10. Сургалтын арга зүй, үнэлгээний аргачлалыг тодорхойлж, суралцагчийн эзэмшсэн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл явц баталгаажсан байх;
- 4.2.11. Багц цагийн системд суурилсан байх;
- 4.2.12. Сургалтын орчин зохих шаардлагыг хангасан байх;
- 4.2.13. Багшлах бүрэлдэхүүн нь зэргийн бус сургалтын хөтөлбөрт заасан суралцахуйн үр дүнг олгох чадамжтай байх;
- 4.2.14. Чанарын баталгаажуулалт хийдэг байх;
- 4.2.15. Зэргийн бус сургалтад зориулан боловсруулсан хичээл нь индекстэй байх;
- 4.2.16. Гэрчилгээг цахим болон хэвлэмэл хэлбэрээр олгох бөгөөд дахин давтагдашгүй дугаартай, зэргийн бус сургалтын мэдээллийн системээр баталгаажуулсан байх.
- 4.3. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг МУИС-ийн Ректорын тушаалаар байгуулагдсан зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хороо хэлэлцэн шийдвэрлэнэ. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хороог Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректорын саналаар 9-11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна.
- 4.4. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хорооны чиг үүрэг:
- 4.4.1. МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний хүрээнд зэргийн бус сургалтын хөтөлбөрийг захиалах, батлах, хаах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.4.2. Чанарын баталгаажуулалтын хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засгийн үр ашиггүй сургалтыг өөрчлөх, түр зогсоох, хаах асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.4.3. МУИС-ийн зэргийн бус сургалтын хөтөлбөрийн нийтлэг шаардлагыг тодорхойлох, хөтөлбөртэй холбогдох удирдамж, заавар, зөвлөмж батлах, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах бодлогын нэгдсэн удирдлагаар хангана.
- 4.4.4. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн давхардлаас сэргийлэх, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж, шийдвэр гаргана.
- 4.4.5. Тэнхимийн хөтөлбөрийн хороодоос ирүүлсэн саналыг хэлэлцэж зэргийн бус сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэр гаргана.
- 4.4.6. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн хэлбэрийн талаарх тэнхимийн хөтөлбөрийн хороодоос ирүүлсэн саналыг шийдвэрлэнэ.
- 4.4.7. Сургалтын хөтөлбөрийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний ажлын удирдамж, зааварчилгаа боловсруулан батална.
- 4.5. Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжийн чиг үүрэг:
- 4.5.1. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хорооны шийдвэрт үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангана.
- 4.5.2. Олон улсын жишиг, салбарын хөгжлийн чиг хандлага, оролцогч талуудын судалгаанд үндэслэн сургалтыг тогтмол сайжруулах чиглэлээр чанарын удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 4.5.3. Хөтөлбөрийн цогц болон хэсэгчилсэн үнэлгээ хийж, үр дүнг зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлнэ.
- 4.6. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн чиг үүрэг:
- 4.6.1. Тэнхимийн хөтөлбөрийн хороо, сургалт зохион байгуулагч нэгжийн үйл ажиллагааг удирдлагаар хангана.
- 4.6.2. Зэргийн бус сургалтад оролцсон багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг хэрхэн тооцох асуудлаар шийдвэр гаргана.

- 4.7. Тэнхимийн хөтөлбөрийн хорооны чиг үүрэг:
- 4.7.1. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ.
- 4.7.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлийн индексийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг зэргийн бус хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ (Хавсралт 1).
- 4.7.3. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр шинээр боловсруулах, өөрчлөх, сургалтыг түр зогсоох, хаах саналыг зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хороонд уламжлан шийдвэрлүүлнэ.
- 4.7.4. МУИС-ийн зэргийн бус сургалтын тайланг гаргаж, хичээлийн жилийн нэгдсэн тайланд тусгана.
- 4.8. Сургалт зохион байгуулагчийн чиг үүрэг:
- 4.8.1. Зэргийн бус хөтөлбөрт тавих шаардлага, загварыг баримтлан сургалтын хөтөлбөр боловсруулж хэлэлцүүлнэ.
- 4.8.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөр боловсруулж, тэнхимийн хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж, зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хороогоор (Хавсралт 1) хэлэлцүүлнэ.
- 4.8.3. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлэх, зохион байгуулах, хөгжүүлэх ажлыг хариуцна.
- 4.8.4. Суралцагчид сургалтын агуулга, суралцахуйн үр дүн, үнэлгээний талаар зааварчилгаа, зөвлөгөө өгнө.
- 4.9. Цахим шилжилт хариуцсан нэгжийн чиг үүрэг:
- 4.9.1. Сургалт мэдээллийн удирдлагын системийг хариуцна.
- 4.9.2. Цахим зэргийн бус сургалтын системийг хөгжүүлнэ.
- 4.10. Багшийн хөгжил хариуцсан нэгжийн чиг үүрэг:
- 4.10.1. Багшийн хөгжлийн хөтөлбөрт хамруулна.
- 4.10.2. Цахим зэргийн бус хөтөлбөр, хичээлийг боловсруулах ажлыг дэмжинэ.
- 4.11. Бүрэлдэхүүн/салбар сургууль, нэгж ба МУИС-ийн түнш байгууллагын хамтарсан сургалтыг хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулна.
- 4.12. Сургалт зохион байгуулагч нь сургалт дууссанаас хойш 14 хоногийн дотор сургалтын тайлан гаргаж, Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид ирүүлнэ. Уг тайланд уралцагч, төгсөгчдийн мэдээллийг заавал багтаах бөгөөд сургалт мэдээллийн удирдлагын системд тухай бүрд нь бүртгүүлнэ.

Тав. Зэргийн бус сургалтын үйл ажиллагаа

- 5.1. Сургалтын зохион байгуулалт
- 5.1.1. Зэргийн бус сургалтын элсэгч, төгсөгч, багшид тавигдах шаардлагыг зэргийн бус сургалтын хөтөлбөрт тодорхойлсон байна.
- 5.1.2. Сургалт зохион байгуулагч элсэгч, төгсөгчдийн бүртгэлийг ,Сургалт хөтөлбөр хариуцсан нэгжид хүргүүлж, зэргийн бус сургалтын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ.
- 5.1.3. Зэргийн бус сургалтын онцлогоос хамаарч шаардлагатай тохиолдолд элсэгчдээс мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг урьдчилан авч болно.
- 5.2. Суралцагчийн бүртгэл
- 5.2.1. Зэргийн бус сургалтад суралцахыг хүссэн иргэд, цахим хэлбэрээр сургалт эхлэхээс өмнө заасан хугацаанд багтаан <https://burtgel.num.edu.mn> системээр бүртгүүлнэ.

- 5.2.2. Суралцах хүсэлт гаргагч бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар цээж зургийг цахим хэлбэрээр хавсаргана.
- 5.2.3. Бүртгүүлэгчийн мэдээлэлд үндэслэн зэргийн бус сургалтад бүртгэж, сургалт мэдээллийн удирдлагын систем ашиглах эрхийг Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжээс суралцагчийн цахим шуудангаар илгээнэ.
- 5.3. Хичээл сонголт, баталгаажуулалт
- 5.3.1. Сургалт зохион байгуулагч хичээлийн ачааллыг багш нарт хуваарилан, баталгаажуулсан цагийн ноогдлыг Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид ирүүлнэ. Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж хичээлийн ноогдол, хуваарийг системд оруулна.
- 5.3.2. Суралцагч сургалтын төлбөрийг бүрэн төлж хичээл сонголтыг баталгаажуулна.
- 5.3.3. Хичээл эхэлсэн эхний оролтын дараа сургалтыг цуцлах бол төлбөрийг 100 хувь буцаан олгоно. Хичээлийн 30 хүртэл хувь орсны дараа сургалтыг цуцлах бол төлбөрийн 30 хувийг суутгаж, 70 хувийг буцаан олгоно. Хичээлийн 30-аас дээш хувь орсны дараа сургалтыг цуцлах бол төлбөрийг буцаан олгохгүй.
- 5.3.4. Анги бүрдэлтийг сургалтын төлбөрт суурилсан санхүүгийн тооцоонд үндэслэн тогтооно.
- 5.3.5. Анги бүрдээгүй шалтгаанаар сургалтыг цуцалсан тохиолдолд бүртгүүлсэн суралцагчдын төлбөрийг шимтгэлгүй буцаан олгоно.
- 5.4. Суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагын үнэлгээ
- 5.4.1. Суралцагчийн хичээлээр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг тэдний бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, суралцагчийн сурах, багшийн сургах хариуцлагыг нэмэгдүүлэх зарчмыг удирдлага болгон дүгнэх бөгөөд үнэлгээ нь шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, шударга, ил тод байна.
- 5.4.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн бүх хичээлд амжилттай үнэлгээ авсан суралцагчид гэрчилгээ олгоно.
- 5.4.3. Амжилтгүй үнэлгээ авсан хичээлийн шалгалтыг дахин өгч болох бөгөөд нэг багц цагийн төлбөр төлж дахин шалгалтад орно.
- 5.4.4. Тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэхдээ суралцагчийн хичээлийн явцын үнэлгээ болон улирлын шалгалтын үнэлгээ тус бүрийг зохих хэмжээгээр тооцон “Суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх аргачлал” -ын дагуу 100 оноогоор үнэлнэ.
- 5.4.5. Тухайн хичээлд 60 ба түүнээс дээш оноо авсан суралцагчийг уг хичээлийн агуулгыг амжилттай судалж, багц цагийг цуглуулсан гэж үзнэ. Харин 60-аас бага оноо авсан суралцагчийг “хангалтгүй” суралцсан буюу тухайн хичээлийн багц цагийг биелүүлээгүй гэж үзнэ.
- 5.4.6. Хичээлийн үнэлгээг “хувьчилсан оноо”-оор үнэлж, “үсгэн” болон “тоо”-оор илэрхийлсэн дүнг дараах хүснэгтийн дагуу харгалзуулна (Хавсралт 4). Үүнд:

Хувьчилсан оноо	Үсгээр илэрхийлсэн дүн
95-100	A+
90-94	A
87-89	B+
83-86	B
80-82	

77-79	C+	ATA13089 9104399 9024080427	ATA13089 9104399 9024080427
73-76	C		
70-72			
65-69	D		
60-64			
0-59	F		

- 5.4.7. Зэргийн хөтөлбөрийн хичээл судалж байгаа тохиолдолд МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмын 4.9 дэх заалтын дагуу үнэлнэ.
- 5.4.8. Тухайн сургалтаас албан ёсоор чөлөө аваагүй, тодорхой шалтгаангүйгээр хичээл огт судлаагүй эсвэл 0 (Тэг) дүнтэй суралцсан суралцагчийг сургалтад оролцоогүй гэж үзнэ.
- 5.4.9. Суралцагч хичээлийн дүнгийн гомдолтой бол хичээл заасан багшид хандана.
- 5.4.10. Тухайн дүнгийн гомдол маргааны дагуу багш “Дүнгийн маргаан, гомдол барагдуулах хүсэлтийн маягт”-ыг бөглөн, гомдол гаргасан суралцагчийн явцын үнэлгээ, улирлын шалгалтын материал зэрэг нотлох баримтыг бүрдүүлэн Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 5.4.11. Дүнгийн гомдол маргааныг хичээл заасан багш хүлээн аваагүй тохиолдолд суралцагч Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид гомдол гаргаж болно. Шаардлагатай тохиолдолд Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар салбарын багш нарын оролцоотой ажлын хэсэг байгуулж, маргааныг шийдвэрлүүлнэ.
- 5.4.12. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг гомдол гаргасан суралцагчийн шалгалтын материал, уг шалгалтын материалыг үнэлж дүгнэхэд баримталсан зарчим, хэрэглэсэн арга зүй, хэрэглэгдэхүүн (бодлого, төстийн хариу зөв эсэх гэх мэт)-ийг хянан магадалж, дахин үнэлсний үндсэн дээр зохих дүгнэлтийг гаргана. Хэрэв ажлын хэсгийн дүгнэлтээр шалгалтын материалыг шударга бус үнэлж дүгнэсэн байвал ажлын хэсгийн өгсөн үнэлгээг (суралцагчийн өмнө нь авсан үнэлгээнээс өндөр эсвэл бага байсан ч) эцсийн үнэлгээгээр тооцно.
- 5.4.13. Дүнгийн маргаан, гомдлын улмаас өөрчлөлт оруулсан дүнг Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж сургалт мэдээллийн нэгдсэн системд оруулна.
- 5.4.14. Багш хичээлийн шалгалтын материалыг бэлдэхдээ МУИС-ийн Сургалтын үйл ажиллагааны журмын 4.12-т заасныг баримтална.
- 5.5. Төгсөлт, гэрчилгээ олгох
- 5.5.1. Энэхүү журмын хүрээнд зэргийн бус сургалтын хөтөлбөрийн бүх хичээлийг амжилттай судалсан төгсөгчид МУИС-ийн зэргийн бус сургалт дүүргэснийг батламжилсан гэрчилгээ олгоно.
- 5.5.2. Гэрчилгээ (Хавсралт 3) нь сургалтын байгууллага болон төгсөгчийн мэдээлэл, үл давтагдах дугаар, сургалтын нэр, агуулга, төрөл, түвшин, хэлбэр, олгосон огноо, хүчинтэй хугацаа, үнэлгээний систем, түвшин, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, үнэлгээ, багц цаг зэргийг багтаасан байх бөгөөд төгссөн эсэхийг баталгаажуулж сургалтын мэдээллийн удирдлагын системд бүртгэгдсэн байна.
- 5.5.3. Гэрчилгээ нь насан туршийн эсвэл тодорхой хугацаанд хүчинтэй байж болно.

- 5.5.4. Зэргийн бус сургалтад хамрагдаж буй болон төгссөн тухай тодорхойлолтыг МУИС-ийн зэргийн бус сургалтын мэдээллийн удирдлагын системээс олгоно.
- 5.5.5. Зэргийн бус сургалтад амжилттай суралцсан төгсөгч нь МУИС-ийн зэргийн сургалтад элсэн орж, суралцах тохиолдолд “МУИС-ийн хичээл дүйцүүлэх журам” болон зэргийн бус сургалт явуулах хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу дүйцүүлэн тооцуулж болно.
- 5.5.6. Сургалтын үргэлжлэх хугацаа дуусахад суралцагч сургалтад оролцоогүй бол Ректорын тушаалаар сургуулиас хасна.

5.6. Хичээл дүйцүүлэх

- 5.6.1. Суралцагчийн өмнө нь судалсан хичээлийг “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-ын дагуу дүйцүүлнэ.
- 5.6.2. Дүйцүүлсэн хичээлийг сургалтын мэдээллийн системд Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж оруулна.

Зургаа. Сургалтын төлбөр

- 6.1. Зэргийн бус сургалтын төлбөрийн хэмжээг сургалтын онцлог, түвшнээс хамааруулан МУИС-ийн Удирдах зөвлөлөөс тогтооно. Зэргийн хөтөлбөрийн хичээлээс бүрдсэн хөтөлбөрийн хувьд МУИС-ийн Удирдах зөвлөлөөс тогтоосон бакалавр, магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрийн багц цагийн үнэлгээг баримтална.
- 6.2. Суралцагчийн сургалтын төлбөр нь суралцагчийн тухайн улиралд баталгаажуулсан хичээлийн багц цаг тус бүрийн төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдоно.
- 6.3. Хичээлийн багц цагийн төлбөр нь Бүрэлдэхүүн/салбар сургууль, хичээлийн түвшин болон төрөл, суралцагчийн элссэн жилээс хамаарч өөр байж болно.
- 6.4. Зэргийн бус сургалтын орлогыг сургалтын төрөл, гэрээнээс хамааруулан тухайн зохион байгуулж буй нэгжийн харилцах дансанд төвлөрүүлэн батлагдсан төсвийн дагуу зарцуулна.
- 6.5. Зэргийн бус сургалтын төлбөрийн орлогын 70 хувийг сургалтыг эрхлэн зохион байгуулж буй Бүрэлдэхүүн/салбар сургуульд, 20 хувийг МУИС-ийн зэргийн бус сургалтын нэгдсэн зохион байгуулалтад, 10 хувийг МУИС-ийн төвлөрсөн санд шимтгэл хэлбэрээр (overhead) тус тус төвлөрүүлнэ.

Долоо. Чанарын баталгаажуулалт

- 7.1. Монгол Улсын боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллагаас гаргасан зэргийн бус сургалтын хөтөлбөрийн талаарх баримт бичиг, шалгуур шаардлагад нийцүүлэн зэргийн бус сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж, үнэлнэ.
- 7.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулахдаа хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг хангасан байдал, сургалтын төлөвлөгөө, оролцогч талуудын үнэлгээ, хүний нөөц, сургалтын арга зүй, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний үнэлгээнд үндэслэн үнэлж, цаашид хөгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж, сургалтын чанарын менежментийн арга зүйг хэрэгжүүлнэ.

- 7.3. Зэргийн бус сургалтын чанарын баталгаажуулалтыг чанарын үндсэн шалгуурын дагуу (Хавсралт 2) дотоод үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл зэрэг аргаар хэрэгжүүлнэ.
- 7.3.1. Дотоод үнэлгээг Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж хөтөлбөрийн шаардлагын дагуу 2 жил тутам хийнэ.
- 7.3.2. Хөндлөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тодорхой давтамжтай хийлгэж болно.
- 7.3.3. Боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагаар сайн дурын үндсэн дээр үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлж болно.
- 7.4. Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж болон сургалт зохион байгуулагч нь сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавина.
- 7.5. Сургалтын дараа суралцагчдаас хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн өөрийн үнэлгээний судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа авна.
- 7.6. Сургалтын талаарх судалгаанд шинжилгээ тогтмол хийж, сургалтын хөтөлбөрийг үнэлэх, сайжруулах, хөгжүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллана.
- 7.7. Зэргийн бус сургалтын чиглэлийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, захиалагчийн шаардлагаас хамааруулан багшид тавигдах шаардлагыг тодорхойлж баримтална. Багш нь тухайн сургалтын чиглэлээр мэргэшсэн мэдлэг, ур чадвартай, магистр болон түүнээс дээш зэргийн боловсролтой байна.
- 7.8. Сургалт зохион байгуулагч, сургалтын чанар, хөтөлбөрийн агуулгын хэлэлцүүлгийг тогтмол хийж, шинэчлэн сайжруулна.
- 7.9. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах арга хэмжээг хоёр жил тутамд авч хэрэгжүүлнэ.

Найм. Бусад зохицуулалт

- 8.1. МУИС-ийн аливаа нэгж, багш байгууллагын эд хөрөнгө, нэр хүнд, цахим болон танхимын сургалтын орчныг ашиглан, энэхүү журмын зохицуулалтыг зөрчсөн зэргийн бус сургалт зохион байгуулахыг хориглоно.
- 8.2. Сургалтын төлбөрийг бэлнээр авах, хувийн дансанд хадгалах, зориулалтын бус зүйлд зарцуулахыг хориглоно.
- 8.3. Зэргийн бус сургалтын зохион байгуулалт болон бусад гомдол, саналыг сургалт зохион байгуулагч болон Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид бичгээр гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 8.4. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөнө.

Хавсралт 1. Бүрдүүлэх материалын жагсаалт

№	Бүрдүүлэх материал
1	Тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
2	Сургалтын хөтөлбөр
3	Хөтөлбөрийн санхүүгийн үр ашгийн тооцоо
4	Хичээлийн хөтөлбөр (индексстэй байх)

5	Хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлт хэрэгцээ, насан туршийн боловсролын олон улсын жишигт нийцсэн, шинжлэх ухааны мэдлэг, ур чадварт суурилсан тухай судалгаа, нотлох баримт
6	Салбарын хууль эрх зүй, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, мэргэшлийн тодорхойлолт, стандарт шаардлага, олон улсын хандлагыг харгалзан үзсэн тухай судалгаа, нотлох баримт
7	Хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх, хөгжүүлэхэд багш, салбарын шинжээч, ажил олгогчдын төлөөллийг оролцуулсан тухай баримт материал
8	Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны маягт
9	Суралцахуйн үр дүнг хүрэх боломжтой, үнэлэгдэхүйц, сургалтын түвшин, агуулга, хэмжээ, хугацаатай уялдсан байдлаар тодорхойлсон байдал
10	Сургалтын арга зүй, үнэлгээний аргачлалыг тодорхойлсон байх, суралцагчийн эзэмшсэн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл явц баталгаажсан байдал
11	Сургалтын арга зүй
12	Үнэлгээний аргачлал, арга зүй
13	Багц цагийн систем, тооцоолол
14	Сургалтын орчны шаардлага
15	Багшид тавигдах шаардлага
16	Элсэгчдэд тавигдах шаардлага

Хавсралт 2. Чанарын баталгаажуулалтын үндсэн шаардлагууд

№	Шаардлага
1	Байгууллага сургалт явуулах нөөц хангалттай байх
2	Багшид тавих шаардлагыг бүх багш нар хангасан байх
3	Зэргийн бус сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг хангасан байх
4	Суралцагчид дэмжлэг, зөвлөгөө өгдөг байх
5	Төгсөгчид тавих шаардлагыг хангасан байх
6	Сургалтын арга зүйн шаардлагыг хангасан байх
7	Үнэлгээний арга зүй, хөндлөнгийн хяналттай байх
8	Чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байх

Хавсралт 3. Зэргийн бус сургалтын төгсөгчдөд олгох гэрчилгээнд тусгах мэдээлэл

№	Мэдээлэл
1	Суралцагчийн мэдээлэл (регистрийн дугаар, овог, нэр)
2	Сургалтын нэр
3	Сургалт зохион байгуулсан улс, засаг захиргааны нэгж, байршил
4	Сургалт зохион байгуулагч байгууллагын нэр
5	Гэрчилгээ олгогч байгууллага
6	Гэрчилгээ олгосон огноо
7	Гэрчилгээний хүчинтэй хугацаа
8	Суралцахуйн үр дүнд хүрэхэд тооцоолсон багц цагийн хэмжээ
9	Сургалтын суралцахуйн үр дүнд харгалзах мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн түвшин (EQF түвшин)
10	Сургалтын түвшин (анхан, дунд ахисан гэх мэт)
11	Сургалтын хэлбэр (танхим, цахим, хосолмол; хээрийн, үйлдвэрлэлийн гэх мэт)

12	Үнэлгээний арга зүй, төрөл, түүний тайлбар (Хавсралт 4)	
13	МУИС-ийн Ректорын элсэлтийн болон төгсөлтийн тушаалын дугаар, батламжилсан гарын үсэг, тамга	
14	Чанарын баталгаажуулалт хийгдсэн байдал, магадлан итгэмжлэгдсэн байдал, түүнийг нотлох тэмдэглэгээ	
15	Дүйцүүлэн тооцох боломж	
16	Сургалтын агуулга, хичээлийн индекс, товч агуулга,	
17	Гэрчилгээ үнэн эсэхийг шалгах арга зам	

Хавсралт 4. Үсгэн үнэлгээний түвшин, агуулга

Үсгээр илэрхийлсэн үнэлгээ	Үнэлгээний 5 түвшний агуулга
+А болон А үнэлгээ:	Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг дээд зэрэг бүрэн гүйцэд, бүтээлчээр ойлгосон, ухагдахуун, ойлголтыг ур чадварлаг ашигладаг;
+В болон В үнэлгээ	Дээгүүр амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгосон, ухагдахуун, ойлголтыг ашиглах ур чадвартай;
+С болон С үнэлгээ:	Тухайн хичээлийн агуулгыг дундаж түвшинд эзэмшсэнийг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг хангалттай ойлгосон, ухагдахуун, ойлголтыг судлах хангалттай бэлтгэлтэй;
D үнэлгээ:	Дундаж түвшнээс доогуур амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахуун, ойлголтыг жигд ойлгоогүй, ерөнхийдөө мэдлэг, ур чадвар, хандлага дутмаг;
F үнэлгээ:	Хангалтгүй амжилтыг илтгэх дүн. Тухайн хичээлийн ухагдахуун, ойлголтыг ойлгоогүй, мэдлэг, ур чадвар, хандлага хангалтгүй;